

Хэсэг 17

Энхийг тогтоогч Монгол, Ойрадууд: Бадамт ширээг хамгаалагч бурханы шашны баатрууд

Рик Таупиер

***Редакторын тайлбар:** Доктор Таупиер санаа бодол хурцалсан чамбай судалгаагаараа урьд нь төдий л хэлэлцэгдэж байгаагүй Төвдийн нэгдэл, Төвдийн бурханы шашинд Монголчуудын гүйцэтгэсэн түүхэн үүргийг бидэнд таниулан баталж байна. Хэд хэдэн түүхэн чухал үе, жишээгээр баримтжуулж, тэрбээр, Монголын хүчин зүйл, ач холбогдлын талаарх бидний ойлголтыг өөрчилж байна. Мөн Др. Таупиер Чингис хаан, түүний өвд үлэмж анхаарал хандуулах нь гадаад ба Монголын дотоодод өөр цаг үеийн бусад Монголын удирдагч, зүтгэлтнүүдэд ач холбогдол өгөхгүй байх байдалд хүргэж байгааг тэмдэглэсэн.*

Тэрбээр Монголчууд өнөөдөр өөрийн түүхийн баялаг байдлыг шинээр нээх, дахин тайлбарлах, дахин батлахын төлөө бичиж байгаа нь зөвлөлтийн үзэл суртал, социалист нийгмийн зүгээс өмнөх түүхээ бичсэн өнгөрсөн далаад жилээс үүдэлтэй үргэлжилсээр байгаа тухай бага хурлын үеэр дурдаж өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн. Архивын бичиг баримтанд тулгуурладаг түүхэн үеүд ихээхэн эмзэг бөгөөд социализмын үед зарим баримт судлаач эрдэмтэд, иргэдэд хаалттай байж саяхнаас олон түмэнд нээлттэй болох зам нээгдэж байна. Ирээдүйд бид Монголын түүхийн ялангуяа Монголчуудын өөрсдийнх нь хийсэн шинэ чухал тайлбар, баталгаа нотолгоо бүхий бүтээлүүдтэй танилцах буй заа.

Оршил

Түүхийг үргэлжид аль нэгэн өнцгөөс бичдэг. Үнэндээ ч тухайн цаг үе, хандах байдлын байр суурьнаас өөрөөр түүхийг ярих ч боломжгүй. Түүхийг харах байдал нь идеологи, угсаатан, үндэстэн, хэл, судлах арга зүй, эх болон хоёрдогч

сурвалжийн мэдлэг гээд олон ч нөлөөн дор хувиран өөрчлөгдөх билээ. Бид энэхүү хязгаарагдмал байдлаас зайлсхийн гарах нь үгүй. Харин тухайн түүхийг аль өнцгөөс харахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг мэдэн ил тод хүлээн зөвшөөрөх байдлаар бага ч атугай багасгаж болно. Бусад түүхчид чухам ямар байр суурьнаас хандсан болохыг тухайн түүхч ямар нөлөөнд автсан болох, ямар өнцгөөс түүхийг харсан мөн хэнд зориулж тухайн түүхийг бичсэнээс нь харахыг хичээдэг. Түүхийн бодит үнэн өнгөгүй байж болох ч түүхийг үргэлжид өнгө будганд урвуулдаг.

Дэлхийн хандлагыг харахад Монгол, Монголчуудын түүхийг бага мэдэн дутуугаар үнэлж цэгнэдэг. Нүүдэлчдийн соёлын хөрсөнд тодрох Монголчуудын түүх нь бусдын хувьд ойлгоход хэцүү. Англи хэл дээр байх Монголчуудын тухай ихэнхи түүх нь Монгол биш суурьшмал иргэншилтэй хүмүүсээс дамжин ирсэн байдаг. Тэдгээр хүмүүс гаднын соёлын нүдээр Монголчуудыг харсан. Чухам тэр гаднын соёлын нүдээр харсан нь хожмоо үл ойлгогдох эс бөгөөс буруугаар тайлагдах байдалд хүргэжээ. Буруу харж тайлан тайлбарласан түүх дахин дахин давтагдаж яригдах тусам улам багжиж засан залруулахад нэн ч хэцүү болдог. Миний үзэхэд Монголын түүх, соёлыг бусад их сонгодог соёлуудын нэгэн адилаар харж судлах хэрэгтэй. Энэ ч утгаар Монголын түүх нь Грек, Перс, Ром, Орос, Хятад эсвэл Төвдийн түүхээс дутуугүй.

Энэхүү бэсрэг өгүүлэлд түүхийг нэгэн тал руу хэлбийлгэн гуйвуулж буй талаар өгүүлэх болно. Энэ нь түүхийн гол талбараас Монголчуудыг шахан гаргаж олон түүхэн үед Монголчууд шалдир булдир түүхэн тоглогч байсан мэтээр өгүүлэх түүхийн хүүрнэлийн тухай юм. Түүхчийн хувьд би Монголчууд, Ойрдуудыг эргүүлэн түүхийн төвд байрлуулан тэдний нүдээр тухайн түүхэн үйл явдлуудыг тайлан харахыг зорилоо. Олон өнцгөөс харж байж л бид Монголчуудын дэлхийн түүхэнд оруулсан хувь нэмрийг нь цогцоор харж эхэлнэ.

Монголын түүхийг даран өгүүлсэн түүхэн хүүрнэлүүдийн нэг нь Манж Чингийн үеийн түүх болно.

Манжийн хаадын хувьд энэ нь зориудын зүйл байв. Манжууд Зүүн Монгол улсыг аажмаар Манжийн эзэнт гүрэнд оруулан уусгаж өөрсдийгөө урьдын Монголчуудын байгуулсан гавьяаг өвлөгч мэтээр дүрслэх болсон. Тэдний хувьд бусдын түүх Их Манж Чин улсын түүхийн нэгэн хэсэг мэтээр харж байв. Чингийн түүх бичвэрийг энэ өнцгөөс харж ойлгож болно.

Төвдийн түүхэн бичвэрүүд ч мөн санаатайгаар бус Монголын түүхийг даран өгүүлсэн. Эхэнд дурдахад төвд түүхчдийн авч хэрэглэсэн түүхэн материал нь Монгол түүхчдийн хэрэглэснээс илүү өргөн хүрээтэй байжээ. Төвдүүд өөрсдөөс бусдыг түрхэн зуурын хүчин хэмээн харан өөрсдийн түүхийг бичжээ. Төвд нь Төв Азийн бурханы шашинд чухал байр суурийг эзэлж байсан бөгөөд тиймд ч бусад соёлыг уг бурханы шашны үзэл санааг хүлээн авагч хэмээн харж байжээ. Учир иймээс Манж Чин улс нь Төвд дангаар биеэ даан Манжтай өрсөлдөгч бусад Төв Азийн хүчнүүдэд шашны зүгээс тэтгэн дэмжиж тэдний эрх мэдлийг хууль ёсны болгох оюун санааны эрх мэдлийг нь хязгаарлан тогтоож өөрийн мэдэлд авах үйл ажиллагааг хүчтэй явуулсан.

Хятад, Төвд болон Монголын зүгээс түүхийг харах байдал өөр өөр байгаа нь сүүлийн тавь жаран жилийн түүхээс ихээхэн хамааралтай. Тусгаар тогтнолоо сэргээхээр тэмцэж буй Төвд олон улсын анхаарлыг нэгэнтээ татаж чадсан. Төвдүүд тусгаар тогтнох хууль ёсны түүхэн нөхцөл байгаа эсэх талаар олон нийтийн санал бодолд нөлөөлөхийн тулд Төвд, Хятадын түүхчид өрсөлдөн түүхэн бичвэрүүдийг бичиж эхэлсэн. Энэхүү маргаан хэлэлцээнд бид ямар байр суурьтай хандах нь энэхүү өгүүллийн гол сэдэв биш юм.

Энэхүү өгүүллийн гол сэдэв бол Төв Ази болон ер нь дэлхийн өнгөрсөн найман зуун жилийн түүхэн үйл явцад Монголчуудын оруулсан хувь нэмрийг дахин нэг шинжлэн харахад оршино. Уг судалгаа нь зөвхөн Чингис хаан, Юан гүрний үеэр эс хязгаарлагдан уг цаг үеэс хойших Монголчууд,

Ойрадууд түүхийн голдрилыг хэрхэн өөрчилсөн, хэрхэн өнгөрсөн түүхийн үр дүнд эдүгээ орчин үеийн Монгол улс үүсэн тогтсон тухай өгүүлнэ. Ийнхүү судлах нь Монголчууд болон бусад нүүдэлчдийн соёл дэлхийн түүхэнд ямар хувь нэмэр оруулсан болохыг хүмүүс танин мэдэж үнэлэхэд хэрэгтэй.

Монголчууд Төвдийн түүхэнд оруулсан хэд хэдэн чухал хувь нэмрийг эргэн харьяа. Нэгэн цагт Төвд нь Төв Ази дахь эзэнт гүрний төв байсныг тэмдэглэх нь зүйтэй. Чингис хаан түүхэнд гарч ирэхээс 300 жилийн өмнө тэрхүү эзэнт гүрэн задран унасан боловч түүний соёлын нөлөө Төв Азид хүчтэй хэвээр байв. Төвдийн Бурханы шашны урсгалууд, тэргүүн лам хуврагууд энэхүү соёлын нөлөөлөлд голлох үүрэгтэй байв. Хэдийгээр гадаад ертөнцөд соёлын нөлөөтэй байсан боловч дотооддоо Төвд улс нь орон нутаг, шашны урсгал хоорондын зөрчил тэмцэлд автагдсан байжээ. Эзэнт гүрэн задран унасан IX зууны төгсгөл үеэс эхлэн язгууртнууд орон нутгийн эрх мэдлийг гартаа авах болсон байна. Харин XI зууны үед тэдгээр язгууртнууд хоорондоо өрсөлдөж байсан Бурханы болон Бонгийн шашны урсгалуудыг тэтгэн дэмжиж хамтрах болжээ. XI зуун нь Төвдийн Бурханы шашны хоёрдох дэлгэрэлтийн үе бөгөөд энэ үед Нинмавийн урсгал дахин сэргэж мөн Гаржуд, Саж болон Гаадамбын урсгалууд үндэслэгч багш нар болон өглөгийн эздийн хүчээр үүссэн тогтсон байна.

Төвдийн эзэнт гүрэн задран унасны дараа Төвдийн төвлөрсөн захиргаа, үндэсний нэгдэл нь зөвхөн гадаад хүчний шууд нөлөөн дор оршин тогтнож байв. XIII зуунаас XVII зуун хүртэл Монголчууд, Ойрадууд тэрхүү гадаад хүчин нь байж Төвдөд амар амгалан, тогтвортой байдлыг тогтоож байв. Энэ үед Төвдүүд олон түүхэн амжилтуудаа гаргасан байна. Өгөөдэй хааны хүү Годан ханы үеэс эхлэн Монголчууд Төвдийн хэрэгт шууд оролцох болсон.

Годан хан Хөх нуурт нутагладаг байсан бөгөөд нийт

Төвд түүний эрх мэдлийн хүрээнд багтаж байв. 1240 онд тэрээр Саж Бандид Гунгаажалцаныг өөрийн өргөөнд ирэн түүнд болон ноёдод Бурханы шашныг сурган заах хэрэгтэй хэмээн зарлигдсан байна. Зарим сурвалжинд тэмдэглэснээр үүний хариуд Саж Бандидад төв Төвдийн арван гурван хэсгийг захирах эрхийг олгожээ. Саж Бандид Төвдүүдэд Монгол хүчний эсрэг зогсох арга байхгүй, албан татварыг төлөн Монголчуудын шашны хэрэгт тусалснаар Төвдийн бурханы шашин өргөн уудам нутагт дэлгэрч болох юм хэмээн зөвлөжээ. Тухайн үеийн тухай энэхүү өгүүлэмж нь хялбаршуулан багасгасан хувилбар мэт харагдана. Үнэндээ Монголчууд Төвдийг өөрийн захиргаанд оруулсны дараахан Төвдөд эрх мэдлийг төвлөрүүлэх үйл явц бүрэн дүүрэн хэрэгжсэн байна.

Саж Бандид 1251 онд Годан хан 1253 онд таалал болжээ. Годан ханы эзэмшил нутгийг өвлөн авсан Хубилай хаан даруйхан Саж Бандидын үеэл дүү Пагва ламтай холбоо тогтоосон байна. Хубилай хаан Пагва ламтай их дотно харилцаатай байв. 1264 онд Пагва ламд зөвхөн төв Төвд бус мөн Амдо, Хам болон баруун Төвдийн шашин төрийг захирах эрхийг олгожээ. Пагва лам 1280 онд таалал болсноос хойш Сажийн урсгал Төвдийг захирч байсан боловч Хубилай хаан 1295 онд тэнгэрт халисны дараахан үеэс эхлэн тэдний Төвд дэх эрх мэдэл сулрах болжээ. Төвлөрсөн захиргаагүй болсноос Төвдөд дотоодын самуун дэгдэж нийт төвийн арван гурван хэсэг үүнд хамрагдсан байна. 1350 онд Пагмодуба хүчирхэгжин эрх мэдлийг авснаар энэхүү самуун дуусгавар болжээ. Монголын Юан гүрний Тогоон Төмөр хаан түүнд төв Төвдийг захирах эрх мэдлийг өгсөн. Юан гүрэн задран унаснаар Монголчуудын Төвдийн хэрэгт шууд оролцох оролцоо үгүй болсон байна.

XVI зууны төгсгөл үеэс Монголчууд дахин Төвдөд нөлөөлөх болсон байна. Харин уг нөлөөлөл нь урьдын нөхцөл байдалтай адил бус байв. XV зууны эхэн үед Богд Зонхов Гэлүг хэмээн нэрлэгдэх болсон Гандан урсгалыг үндэслэжээ. Хожмоо

Далай лам болсон Зонховын шавь Гэндүндуб шарын шашны институтыг үүсгэн тогтооход үндсэн үүргийг гүйцэтгэсэн. Шарын шашны хамгийн анхны хувилгаан дүрээр тодорсон II Далай лам улмаар түүний уг үйлсийг үргэлжүүлжээ. III Далай ламын үед шарын шашин нь олон шавь, өглөгийн эзэдтэй болсон байв. Илүү нөлөө ихтэй болсноор шарын шашны нөлөө болон өглөгийн эздийн өглөг тэдний зүгт урсахаас болгоомжилсон өрсөлдөгч дайсны тоо ч мөн нэмэгдсэн байна. Уг нөхцөл байдалд Түмэдийн Алтан хан бурханы шашныг дэлгэрүүлэхээр Содномжамцыг 1576 онд Хөх нуурт урихад Содномжамц болон шарын шашныг бишрэн дагагчид хүчирхэг Монголчуудын ивээлээр харгалдах дайснаас аврагдана хэмээн ихэд баяртай хүлээн авчээ.

Хэдийгээр Төвдийн хэрэгт шууд эс оролцсон боловч Монголчуудын дэмжлэг, хамгаалалт нь Далай ламын институтийг үүсгэн байгуулж Далай ламыг зөвхөн Төвдийн оюун санааны удирдагч бус харин Төв Азийн удирдагчаар тохоон томилсон хэрэг болсон юм. Үүний сацуу шарын шашны институтийг дэмжих ихээхэн хэмжээний өглөгийн урсгалыг бий болгосон байна. Монголчууд хэрэв эс тэтгэсэн бол шарын шашин “нас биенд” хүрэлгүйгээр гандан гундаж эцэслэх байсан болов уу хэмээн хэлэхэд худал болохгүй нь лавтай.

III Далай Лам Хөх нуурт Гүмбүм хийдийг байгуулсан. Автай сайн хан бурханы шашинд орсноор Содномжамц болон шарын шашны нөлөө төв Монголд орж иржээ. Монголчууд тэтгэн дэмжсэний хариу нь IV Далай лам Алтан ханы ач болон төрсөн нь үйлийн барилдлага гэмээр. Хошууд, Халимагуудыг эс тооцон Төвд бус ямар ч үндэстэн Далай ламтай ийм их үйлийн барилдлагатай нь үгүй. Эдүгээ түүнийг өөрийн нэгэн адил үздэг. Хүчирхэг Монгол морьт цэргүүдийн хамтад IV Далай лам Лхасд морилсон нь Монголчууд Далай лам, шарын шашныг өмгөөлөн хамгаалж байх болно гэсэн дохио байв.

1617 онд IV Далай лам насан эрт таалал болсны дараа Манжууд Монгол Төвдийн дундуур орж иржээ. Энэ үед Монголчууд нэгдэлгүй байв. Цахар Монголчууд шарын шашин, залуу V Далай Ламын эсрэг хөдлөв. Цахарууд 1637 онд Төвд рүү цэрэг илгээх үед Ойрадыг захирч байсан Гүш хан шарын шашныг өмгөөлөн босчээ. Ийнхүү Ойрадууд Далай Ламыг тэтгэн хамгаалах дараагийн хамгаалагчид болсон юм. Гүш хан ихэнх Хошууд Монголчуудыг Хөх нуурт авчирсан бөгөөд тэдгээр Монголчууд одоо ч Хөх нуурт нутаглаж байна. Гүш хан зөвхөн Далай Ламыг Цахар Монголчуудаас хамгаалаад зогсохгүй Далай Ламыг эсэргүүцэгч Төвдүүдийг тэгшитгэн номхруулжээ.

Төвдийг захирснаар Гүш хан үнэндээ Төвдийн хаан болсон бөгөөд уг цолыг ч залуу Далай лам өгчээ. 1642 онд Гүш хан Годан хан, Хубилай хааны адилаар V Далай ламд мандал өргөн нийт Төвдийн шашин, төрийг хослон барих эрх мэдлийг түүнд өргөжээ. Үр дүнд нь Төвд дахин төвлөрсөн захиргаатай болж Төвдийн алтан үе хэмээгддэг удаан хугацааны тогтвортой байдал, дэвшил хөгжлийг авчирсан байна. XVIII зуунд Хошууд Монголчуудын хүчин буурч Манжууд хүчирхэгжиж эхэлжээ. Монголчууд Далай ламыг Төв Азийн оюун санааны удирдагчаар тохоон томилсон бол Ойрадууд Далай ламыг Төвдийн улс төрийн удирдагч болгосон гавьяатай. Харамсалтай нь тэр нь одоо цөллөгөнд оршин тогтнож буй Төвдийн засгийн газрын суурь билээ.

Эдүгээ Төвдийн соёлыг Төв Азийн сонгодог соёлуудын нэг хэмээн дэлхийд хүлээн зөвшөөрч байна. Тэгвэл цөөхөн тооны хүмүүс л энэ их соёлыг бүтээхэд Монголчууд олон зууны турш хэрхэн тэтгэн дэмжиж ирснийг мэдэж байна. Түүхэн бодит байдлыг нэг тийш эс хэлбийлгэн зөвхөн Чингис хааны үеэр зогсолгүй өнгөрсөн мянга мянган жилийн тэртээгээс одоог хүртэл Монголчуудын байгуулсан олон түүхэн гавьяа зүтгэлийг үнэлэх хэрэгтэй. Эс яригдах дурсагдах

түүхийн нэгээхэн хэсэг билээ. Дэлхийн түүхэнд оруулсан Монголчуудын түүхэн үүргийг сайн шинжлэн судлах нь Төв Азийн тухай үнэнийг барьсан мэдлэг, мэдээллийг тогтооход нэн чухал байна.

Монголын түүхэнд нэгэн чухал цаг үеийг дахин нягтлан харж энэхүү өгүүллээ өндөрлөе. Монголчууд ихэнхдээ зөвхөн Чингис хааныг өөрийн түүхэн үүрэгт соёлын баатраар хардаг нь надад гайхалтай санагдсан. Гурван жилийн өмнө би антропологч Л.Мөнх-Эрдэнээс Монголчууд яагаад Монголын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн Чингэс хаанаас хойших үеийн түүхэн зүтгэлтнүүдийг эс ойшоосон маягтай байдаг талаар асуун мөн түүнээс орчин үеийн Монголыг үүсгэн байгуулахад хэн нэн чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг асуусан. Түүний хариулт намайг ихэд гайхашруулсан. Тэр Галдан бошигт гэж хэлсэн. Галдан бошигт нь манжийн хараа хяналтаас чөлөөт байсан Монголчуудыг Манж Чин улсад дагаар ороход хүргэсэн хүн. Яагаад Занабазар биш гэж асуухад тэрээр хүмүүс түүнийг Манжид буун өгч Монголын эрх чөлөөг алдуулсан гэж шүүмжилдэг юм гэж хариулсан. Үнэндээ Манжийн захиргаа Монголын хөгжлийг саатуулсан бөгөөд түүний шарх сорви одоог хүртэл байдаг.

Тухайн түүхэн явцыг харьяа. Хэрэв Занабазар Манжид дагаар орох шийдвэр гаргаагүй байсан бол? Хэрэв Занабазар Зүүнгарын улстай хүч нэгдэн Манжийн эсрэг тэмцэн ялагдсан бол Монгол нь Хөх нуур, Өвөр Монгол, Зүүнгарын нэгэн адил Манж Чин улсын бүрэн захиргаанд орох байсан уу? Хэрэв ийм зүйл тохиосон бол Монгол нь ердөө л Хятадын нэгэн муж болон хан Хятадууд эзэгнэн тусгаар тогтнолоо 1911 онд сэргээж чадахгүй байх байсан болов уу. Занабазарын Манжид дагаар оруулсан үндэстэн эдүгээ оршин тогтнож байна. Харин Зүүнгарын улс эдүгээ үгүй. Зүүнгар Монголын зөрчилд орж байсан энэ үндэстэн 1990 онд өөрийн замнах замаа сонгож дэлхийн эрх чөлөөт үндэстнүүдийн дунд өөрийн эзлэх

байртай, хэлэх түүхтэй, хадгалан хамгаалах соёлтой, өөрийн ирээдүй замналыг тогтоох эрхтэй Монгол үндэстэн юм.

Өнөөдрийн орчин үеийн Монгол оршин тогтнож байгаа нь ямар нэгэн байдлаар Занабазарын ач тус хэмээн хэлж болох юм. Хэрэв бид Монголчууд Манжийн дарлалд зовж зүдэрсэн нь түүнээс болсон гэж шүүмжлэх юм бол мөн одоогийн Монгол улс эрх чөлөөтэй, өөрт засаглах эрхтэй байгаа нь бас түүний гавьяа зүтгэл болохыг хэлэх нь зүйтэй. Монголчууд, Ойрадууд энх тайвныг хамгаалагч гэж энэхүү өгүүллээ нэрлэсэн маань үүнтэй холбоотой. Өнгөрсөн гурван зууны тэртээ гаргасан шийдвэр буруу мэт байвч Занабазар энх амгаланг сонгосон. Хожим гавьяа зүтгэлийг нь үнэлэх ухаалаг шийдвэр гаргасан. Буддын гэгээнтнүүдийн эрхшээсэн билгийн нүдээр хүнд хэцүү зам мэт боловч ашдын эрх чөлөөг авчирна гэдгийг Өндөр Гэгээн Занабазар болгоосон байх.

Түүх гайхамшигтай сонин. Одоогийн өндөрлөгөөс түүнийг эргэн харж судлан танин мэдсэнээр ирээдүйд тус болох сургамжийг авч болно.